

ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ
№ND/221-12-2-41164558 (81/22)

2022 оны 03-р сарын 15-ны өдөр Дархан-Уул аймаг
Нэг талаас "ДДЦС"ТӨХК /цаашид "Даатгуулагч" гэх/, нөгөө талаас "Номин Даатгал" ХХК
/цаашид "Даатгагч" гэх/ нар /цаашид хамтад нь талууд гэх/ харилцан тохиролцсоны үндсэн
дээр МУ-ын Иргэний хуулийн 43 дугаар бүлэг, Даатгалын тухай хуулийг удирдлага болгон
дараах нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээгээр даатгагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тохиолдсон даатгалын эрсдэлийн улмаас даатгалын тохиолдол болсон нөхцөлд нөхөн төлбөрийг төлөх, даатгуулагч нь даатгагчид даатгалын хураамж төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Даатгалын хугацаанд даатгагчийн хүлээх хариуцлага нь даатгалын зүйл тус бүр дээр тухайн зүйл тус бүрийн даатгалын үнэлгээнээс хэтрэхгүй байна.
- 1.3 Талууд гэрээг харилцан зөвшөөрч, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан, даатгалын хураамж төлөгдсөн байх нөхцөлүүд зэрэг хангагдсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.
- 1.4 Даатгуулагчийн даатгуулахаар бүрдүүлж өгсөн материалууд, мэдүүлэг нь гэрээний хавсралт буюу гэрээний үндэс болно.
- 1.5 Энэхүү гэрээг даатгалын баталгаа дагалдах бөгөөд 22111000500992 тоот баталгаанд даатгалын үнэлгээ, даатгалын хураамжийг заавал бичнэ.
- 1.6 Талууд энэхүү гэрээнд хэрэглэгдэх үгсийг дор дурдсан утгаар ойлгох бөгөөд даатгалын баталгаанд ижил утгаар хэрэглэгдэх болно. Үүнд:
 - 1.6.1 Даатгагч - Даатгалын тухай Монгол Улсын хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан НОМИН ДААТГАЛ ХХК-ийг;
 - 1.6.2 Даатгуулагч - Өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг
 - 1.6.3 Даатгалын зүйл - Даатгуулагчийн даатгуулахаар мэдүүлж буй гэрээ, даатгалын баталгаанд заагдсан авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн хариуцлагыг;
 - 1.6.4 Даатгалын мэдүүлэг - Даатгалын зүйлийг тодорхойлж байгаа төрөл бүрийн баримт материал, мэдээллийг;
 - 1.6.5 Даатгалын баталгаа - Даатгуулагчийн даатгуулсныг баталгаажуулж, гэрээнд хавсарган даатгуулагчид олгох баталгаа бичгийг;
 - 1.6.6 Даатгалын үнэлгээ - Даатгалын зүйлийн үнийг үндэслэн даатгагч, даатгуулагч нар харилцан тохиролцсон үнийг;
 - 1.6.7 Даатгалын хураамж - Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;
 - 1.6.8 Даатгалын тохиолдол - Даатгалын зүйлд даатгалын эрсдэлийн улмаас хохирол учрахыг;
 - 1.6.9 Зам тээврийн осол - Зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрах үйлдлийг;
 - 1.6.10 Зайлшгүй зогсолт- жолооч, зорчигчийн биеийн байдал, тээж яваа ачаа, байгалийн үзэгдэл, зам дээр саад бий болсон зэргээс аюул учирч болзошгүй үед, түүнчлэн техникийн эвдрэлээс шалтгаалан тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоох үйлдлийг;
 - 1.6.11 Зориулалтын зогсоол - Дараах зогсоолын төрлүүд хамаарна. Үүнд:
 - 1.6.11.1 Авто тээврийн хэрэгслийн зогсоол (цаашид авто зогсоол гэх) - зөвхөн авто тээврийн хэрэгсэл байрлуулах (зогсоолын) зориулалттай барилга, байгууламж (барилга, байгууламжийн хэсэг), түр буюу удаан хугацаагаар байрлуулах зориулалтын талбай.
 - 1.6.11.2 Газар дээрх битүү авто зогсоол- гадна хашлага бүтээц бүхий авто тээврийн хэрэгслийн зогсоол.
 - 1.6.11.3 Задгай авто зогсоол- гадна хашлага бүтээцгүй авто тээврийн хэрэгслийн зогсоол. Задгай авто зогсоолд мөн харьцангуй урт хэмжээний хоёр талаасаа задгай байгууламж хамаарна.

- 1.6.11.4 Налуу пандус (рамп)-тай авто зогсоол- тойруугаар тогтмол өгсөх (буух) эсвэл, давхар хооронд холбох пандус буюу налуу замаар авто тээврийн хэрэгсэл түвшин хооронд шилжих боломж бүхий авто зогсоол.
- 1.6.11.5 Механикжсан авто зогсоол- жолоочийн оролцоогүйгээр зориулалтын механикжсан төхөөрөмжөөр авто тээврийн хэрэгслийг байрлуулах зогсоолд зөөвөрлөн байрлуулах боломжтой зогсоол
- 1.6.12 Гарааш - Өмчийн болон түрээсийн хэлбэрээр ашиглагдаж байгаа авто тээврийн хэрэгсэл агуулах зориулалт бүхий байгууламжийг;
- 1.6.13 Гал түймэр- хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн болон хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгалийн баялаг, нийгэмд хохирол учруулах шаталтыг;
- 1.6.14 Нөхөн төлбөр - Гэрээнд заасан даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас гэрээний дагуу даатгуулагчид учирсан хохирлыг буцаан төлөх;
- 1.6.15 Нөхөн төлбөр олгохгүй нөхцөлүүд - Даатгагч нөхөн төлбөр олгохгүйгээр гэрээнд заасан нөхцөлүүдийг;
- 1.6.16 Бүрэн сүйрэл - Даатгалтай авто тээврийн хэрэгслийн хохирлын хэмжээ нь зах зээлийн тухайн үеийн бодит үнэлгээтэй тэнцүү буюу давсан тохиолдлыг авч үзэх бөгөөд хохирлын үнэлгээ болон зах зээлийн бодит үнэлгээг даатгалын мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлт дээр тулгуурлан тогтооно;
- 1.6.17 Хэсэгчилсэн хохирол - Бүрэн сүйрлээс бусад тохиолдлыг;
- 1.6.18 Нэмэлт тоноглол хэрэгслүүд - Үйлдвэрээс тавигдаагүй эд анги, тоноглолыг;
- 1.6.19 Үлдэгдэл хэсэг- Даатгалын эрсдэл учирсан даатгалын зүйлийн ашиглагдах боломж бүхий хэсгийг;
- 1.6.20 Хууль бус үйлдэл- Санаатайгаар хууль зөрчсөн үйлдэл;

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Даатгалын гэрээ 2022 оны 03-р сарын 15 өдрийн 00:00 цагаас эхлэн 2023 оны 03-р сарын 15-ны өдрийн 24:00 цаг хүртэл 1 жил /сар/-ын хугацаанд хүчинтэй байна.
- 2.2 Даатгалын гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
- 2.2.1 Хууль, гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;
- 2.2.2 Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;
- 2.2.3 Даатгуулсан эд хөрөнгийг шүүхийн шийдвэрээр хураасан;
- 2.2.4 Талууд тохиролцож гэрээг цуцалсан;
- 2.2.5 Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;
- 2.3 Гэрээний хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө талууд гэрээний хугацааг сунгах тухай хүсэлтээ албан ёсоор мэдэгдэж гэрээг шинээр байгуулах бөгөөд даатгалын баталгааг шинэчилнэ.

Гурав. Даатгалын зүйл

- 3.1 Даатгуулагчийн буруутай үйлдлийн улмаас гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага

Дөрөв. Даатгалын эрсдэл

- 4.1 Дараах эрсдэлүүдээс сонгосон эрсдэлүүд хамаарагдана. Үүнд:

Даатгалын эрсдэлийн төрөл	Сонголт
Даатгуулагч замын хөдөлгөөнд оролцож явахдаа бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах	
Даатгуулагч замын хөдөлгөөнд оролцож явахдаа бусдын эд хөрөнгөнд хохирол учруулах	
Даатгуулагчийн тээврийн хэрэгсэлд зорчиж явсан этгээдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах	

Тав. Даатгалын үнэлгээ, даатгалын хураамж

- 5.1 Даатгуулагч нь авто тээврийн хэрэгсэл эзэмшигчийн хариуцлагыг 145,000,000.00 /Нэг зуун дөчин таван сая/ төгрөгөөр үнэлсэн болно.
- 5.2 Даатгалын хураамжийг даатгалын үнэлгээнээс ЖХАЖДаатгалын 3.1.3 дахь заалтыг үндэслэн 2,345,895.00 /Хоёр сая гурван зуун дөчин таван мянга найман зуун ерэн тав/-н төгрөг төлөхөөр харилцан тохиролцов.
- 5.3 Даатгалын хураамжийг гэрээ байгуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор даатгагчид төлнө.
- 5.4 Даатгалын хураамж гэрээний 5.3-т заасан хугацаанд төлөгдөөгүй бол даатгалын

гэрээний хамгаалалт даатгалын хураамж төлөгдсөн өдрөөс эхлэн үйлчилж эхэлнэ.

Зургаа. Нөхөн төлбөр

- 6.1 Даатгагч нөхөн төлбөр олгохгүй нөхцөлүүд хэсэгт заагдсанаас бусад тохиолдолд даатгалын эрсдэлийн улмаас даатгалын зүйлд учирсан хохирлыг даатгалын үнэлгээнд багтаан нөхөн төлнө.
- 6.2 Даатгагч нь даатгуулагчийн сонгосон даатгалын хамгаалалтад заасан хувиар нөхөн төлбөр олгоно.
- 6.3 Даатгуулагчийн хариуцах хэсэг болон нэмэлт үйлчилгээ нь даатгуулагчийн сонгосон хамгаалалтаас хамаарч өөрөөр тогтоогдох бөгөөд дараах нэмэлт үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

№	Даатгалын эрсдэл	Хамгаалалтын төрөл		
		А	Б	В
1	Даатгуулагч замын хөдөлгөөнд оролцож явахдаа бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан хохирол	100%	100%	80%
2	Даатгуулагч замын хөдөлгөөнд оролцож явахдаа бусдын эд хөрөнгөнд учруулсан хохирол	100%	80%	80%
3	Даатгуулагчийн тээврийн хэрэгсэлд зорчиж явсан этгээдийн амь нас, эрүүл мэндэд учруулсан хохирол	100%	-	-

- 6.4 Даатгуулагчийн хариуцах хэсэг даатгуулагчийн сонгосон хамгаалалтын төрлөөс хамаарч 20 хүртэлх хувиар тогтоогдоно.
- 6.5 Даатгуулагч авто тээврийн хэрэгслээ жолоодож байхдаа осол гаргасны улмаас хуулийн хариуцлага хүлээсэн эсвэл даатгагч гарсан хохирол, хүлээх хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд уг хохирлын дүнгээс даатгуулагчийн хариуцах хэсгийг хасаж нөхөн төлбөрийг олгоно.
- 6.6 Даатгалын үнэлгээний 50%-аар гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэндэд учруулсан хохирлыг, үлдсэн 50%-аар эд хөрөнгөнд учруулсан хохирлыг нөхөн төлнө.
- 6.7 Гэрээ болон даатгалын баталгаанд нэр заагдсан даатгуулагчид даатгалын хамгаалалт үйлчилж нөхөн төлбөр олгогдоно.
- 6.8 Даатгалын тохиолдол бий болоход даатгуулагч нь даатгалын зүйлийг бусад даатгалын компанид давхардан даатгуулсан тохиолдолд учирсан хохирлыг дараах байдлаар шийдвэрлэнэ. Үүнд:
- 6.8.1 Бусад даатгалын компани даатгуулагчид учирсан хохирлыг бүрэн барагдуулсан нөхцөлд нөхөн төлбөр олгохгүй.
- 6.8.2 Бусад даатгалын компани даатгуулагчид учирсан хохирлыг хэсэгчлэн төлсөн тохиолдолд үлдэх хэсгийг даатгагч нөхөн төлнө. Ингэхдээ даатгалын компаниудын олгох нийт нөхөн төлбөрийн хэмжээ нь бодит хохирлын хэмжээнээс хэтрэхгүй байна.
- 6.9 Даатгагч нөхөн төлбөрийн нэхэмжлэл болон бусад баримт материалыг хүлээн авч шаардлага хангасан гэж үзвэл материал бүрэн бүрдүүлж өгснөөс хойш хохирлын дүнгээс хамаарч ажлын 7 хоногийн дотор нөхөн төлбөрийг шийдвэрлэнэ.
- 6.10 Даатгуулагч нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргахдаа дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
- 6.10.1 Хохирол нөхөн төлүүлэх тухай даатгуулагчийн өргөдөл, албан бичиг;
- 6.10.2 Даатгалын гэрээ болон даатгалын баталгаа;
- 6.10.3 Авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ, жолоочийн жолооны үнэмлэхийн хуулбар
- 6.10.4 Аюул осол болсон тухай холбогдох мэргэжлийн байгууллагын акт, тодорхойлолт, хохирлын үнэлгээ /Замын цагдаагийн газар, ОБЕГ газар, Шүүх, прокурор, холбогдох засаг захиргааны байгууллага, үнэлгээний байгууллага гэх мэт/;
- 6.10.5 Хохирлын эд мөрийн баримт, нотолгоо, бусад холбогдох материал, фото зураг
- 6.11 Талууд даатгалын хохирлын үнэлгээг даатгалын мэргэжлийн хохирол үнэлгээний байгууллагаар хийлгэх бөгөөд аль нэг тал нь үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд хохирол шийдвэрлэх хугацааг ажлын 14 хоног хүртэл сунгаж болно.
- 6.12 Даатгалын тохиолдол нь хуулийн байгууллагаар үргэлжлүүлэн шалгагдаж байгаа нөхцөлд нөхөн төлбөр шийдвэрлэх хугацааг сунгаж болно.
- 6.13 Даатгуулагч даатгалын гэрээгээр тохиролцсоноос бусад тохиолдолд хураамжаа хэсэгчлэн төлж байх үед даатгалын эрсдэл учирсан тохиолдолд төлсөн хураамжид

- ногдох даатгалын үнэлгээнээс нөхөн төлбөрийг тооцож олгоно.
- 6.14 Даатгагч дараах үндэслэлээр нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзаж болно. Үүнд:
- 6.14.1 Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан эсвэл даатгалын тохиолдол бий болох нөхцөл орчныг бүрдүүлсэн;
- 6.14.2 Даатгуулагч эсвэл түүний төлөөлөгч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- 6.14.3 Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;
- 6.14.4 Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл;
- Долоо. Нөхөн төлбөр олгохгүй нөхцөлүүд
- 7.1 Талууд гэрээг харилцан зөвшөөрч, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан, даатгалын хураамж төлөгдсөн байх нөхцөлүүд зэрэг хангагдаагүй.
- 7.2 Даатгуулагч болон түүний зөвшөөрөлтэй этгээд осол болох үед
- 7.2.1 согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм хэрэглэсэн байсан;
- 7.2.2 зохих байгууллагын дүгнэлтээр хэт ядарсан, автомашин жолоодох чадамжгүй байсан нь тогтоогдсон;
- 7.2.3 жолоодох эрхгүй байсан;
- 7.3 Даатгуулагчийн сонгосон хамгаалалтын төрөлд ороогүй болон нэмэлт хураамж төлж даатгуулаагүй эрсдэлүүдийн улмаас учирсан хохирол, түүний үр дагавар;
- 7.4 Даатгуулагч даатгагчид мэдэгдэхгүйгээр бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөнд учруулсан хохирлоо ямар нэгэн хэлбэрээр төлсөн, харилцан тохиролцсон
- 7.5 Урсгал сөрсөн, замын зохицуулагч болон зохицуулах дохио зөрчсөн болон зайлшгүй шалтгаанаас бусад тохиолдолд замын зорчих боломжгүй хэсгээр зорчсон /замын хашлага, ногоон байгууламж, явган зорчигчийн зорчих талбай/
- 7.6 Ажлын тормосны систем, жолооны механизм ажиллахгүй болсон, чиргүүлийн холбоос эвдэрснээс үүсэн учирсан хохирол
- 7.7 Харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед зөв талын хол, ойрын болон ар талын оврын гэрлүүд асахгүй болсноос учирсан хохирол
- 7.8 Дугуйн хэмжээ, даац нь тээврийн хэрэгслийн тухайн төрөлд тохироогүй болон нэг тэнхлэгт өөр марк, хээтэй дугуй тавьснаас учирсан хохирол;
- 7.9 Цас бороо орж байгаа үед жолоочийн талын шил арчуур ажиллагаагүй байснаас учирсан хохирол
- 7.10 Даатгуулагчийн хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирол;
- 7.11 Хохирол гарсан шалтгаан, байрлал, хугацааны аль нэг нь тодорхойгүй нотлох боломжгүй гарз хохирол;
- 7.12 Төрөл бүрийн хүү, торгууль, алданги болон гуравдагч этгээдийн ирээдүйд олох байсан ашиг орлого
- 7.13 Даатгуулагчаас бусад этгээд авто тээврийн хэрэгслийг жолоодож явахдаа бусдад учруулсан хохирол
- 7.14 Даатгуулагч өөрийн гэр бүлийн гишүүдэд учруулсан хохирол
- 7.15 Даатгуулагчийн өөрийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, ачиж явсан ачаа бараанд учирсан хохирол
- 7.16 Даатгуулагч бусдын эзэмшлийн авто тээврийн хэрэгслийг жолоодож явахдаа уг авто тээврийн хэрэгсэлд болон авто тээврийн хэрэгсэл дотор байсан эд хөрөнгөнд учруулсан хохирол
- 7.17 Хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд цагдаагийн байгууллагад аваар ослын талаар газар дээр нь мэдэгдэж үзлэг шалгалт хийлгэн акт дүгнэлт гаргуулаагүй, гэрээнд заасан хугацаанд даатгагчид мэдэгдэж, хохиролтой холбоотой материалыг даатгагчид ирүүлээгүй;
- 7.18 Цацраг идэвхт бодис, цөмийн зэвсэг, цөмийн түлш, тэсрэх бөмбөг бусад тэсрэх бодис, байлдааны зэвсгийн үйлчилгээнээс үүдэлтэй шууд болон шууд бус үр дагавраас шалтгаалсан хохирол болон даатгалтай авто тээврийн хэрэгслийг тэсрэх шатах аюул бүхий бодис, бүтээгдэхүүн ачиж зөөвөрлөхөд ашигласны улмаас учирсан хохирол;
- 7.19 Дайн байлдаан, улс төрийн болон террорист үйл ажиллагаа, ажил хаялт, төрийн эргэлт, бослого, үймээн самууны үр дагавар;
- Найм. Даатгуулагчийн эрх, үүрэг
- 8.1 Даатгуулагч гэрээгээр хүлээх үүрэг, өөрийн зүгээс хийвэл зохих зүйлсийн талаарх

хасаж үлдэх хэсгийг даатгуулагчид буцаан олгоно.

10.6 Даатгуулагч тал даатгалын гэрээ байгуулахдаа санаатайгаар буруу мэдээлэл өгсөн, даатгалын зүйлийн даатгуулах үеийн бодит байдлыг Даатгагчид харуулан зургаар баталгаажуулах нөхцөлөөр хангаагүй нь даатгалын гэрээ байгуулсны дараа мэдэгдсэн тохиолдолд Даатгагчийн санаачилгаар гэрээг цуцалж даатгалын хураамжаас даатгалтай холбогдон гарсан бүх зардлыг хасаж үлдэх хэсгийг даатгуулагчид буцаан олгоно.

10.7 Талуудын аль нэг нь гэрээг цуцлах санал гаргавал нөгөө талдаа ажлын 10 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

10.8 Гэрээг цуцлах санал хүлээн авсан тал нь хариуг ажлын 3 хоногийн дотор ирүүлээгүй бол гэрээ цуцлах саналд заасан өдрөөс эхлэн гэрээг цуцлагдсанд тооцно.

Арван нэг. Маргаан шийдвэрлэх

11.1 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад үүссэн аливаа маргаантай асуудлыг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба хэрэв эв зүйгээр шийдвэрлэх боломжгүй нөхцөлд Санхүүгийн Зохицуулах Хороонд хандаж шийдвэрлүүлнэ.

11.2 Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэрийг аль нэг тал эс зөвшөөрвөл холбогдох хуулийн дагуу шүүхэд хандана.

Арван хоёр. Гэрээний нууцлал

12.1 Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах тул талууд бусад этгээдэд тараах, дамжуулах, хэвлэн тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.

12.2 Тус шаардлагыг биелүүлээгүй талд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Арван гурав. Талуудын албан ёсны хаяг

Даатгагч:
Дархан-уул аймаг, Дархан сум
15-р баг Номин бизнес төв
Утас: 89887829, 89887807
Факс: 75779999
E-мэйл: insurance@nomin.net

Даатгуулагч:
Дархан-уул аймаг, Дархан сум
13-р баг, Үйлдвэрийн дүүрэг
Утас: 99069112, 99995993
Факс: 70373021
E-мэйл: darhanpp@mongol.net

Даатгагчийг төлөөлж:
НОМИН ДААТГАЛ ХХК-ИЙН
ДАРХАН САЛБАРЫН ЗАХИРАЛ
Ш.ЭРДЭНЭЦЭЦЭГ
ДАРХАН САЛБАР

Гэрээ байгуулсан
Даатгуулагчийн төлөөлж:
ДААТГУУЛАГЧИЙН
ДУЛГААНЫ ДУЛААН
ЦЭЦЭГ
ТЭХИЙН
ЦЭЦЭГ
ЭХ
ЗАХИРАЛ
М.ЖАРГАЛСАЙХАН
ТАМ0044
2688546

СБХ-ИЙН ДАРГА
.....Ц.УУГАНБАЯР
ХҮХ-ИЙН ДАРГА
.....Э.АЛТАНТУЛГА
ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН
.....Г.ОЮУНБИЛЭГ

		Тийм	Үгүй	Гарын үсэг
1	Мэдүүлгийн маягыг үнэн зөв бөглөсөн	Тийм	Үгүй	
2	Даатгалын гэрээний бүх зүйл заалтыг хүлээн зөвшөөрөв	Тийм	Үгүй	
3	Мэргэшсэн болон С, D ангиллын даатгал хийлгэх үү	Тийм	Үгүй	
4	Тээврийн хэрэгсэлийн өмчлөгч мөн эсэх	Тийм	Үгүй	